

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.08.26 - 08.30

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Хөрөнгө оруулагчид АНУ болон БНХАУ хоорондын худалдааны маргаан АНУ-д ашигтай үр дүн авч ирлээ хэмээн үзэж, ийнхүү хөрөнгийн зах зээлийн индексүүд сүүлийн 3 сарын хугацаанд үзэгдээгүй өндөр өсөлттэй байв. Арилжааны хэмжээ 7 хоногийн эхэн үеэр бага байсан ч томоохон хөрөнгө оруулагчид сарын сүүлээс өмнө багцын тэнцвэрээ хадгалах зорилгоор арилжаанд ихээхэн оролцжээ.

S&P индексийн сагсанд багтах аж үйлдвэрлэлийн салбарын компаниудын хувьцаа хамгийн ихээр өссөн ба тэр дундаа "UPS" компанийн хувьцаа хамгийн их өсөлт үзүүлжээ. Харин эрүүл мэнд, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон үл хөдлөх хөрөнгийн салбарын компаниудын хувьцаа уналттай хаагдлаа.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп өнгөрөгч долоо хоногийн Баасан гарагт БНХАУ-аас ирэх импортын бүтээгдэхүүнүүдэд ногдуулсан гаалийн татварын хэмжээг дахин нэмэхээ мэдэгдсэн бол БНХАУ-ын эрх баригчид АНУ-тай ямар нэг хэлэлцээр хийх сонирхолгүй байгаагаа илэрхийлсэн. Энэхүү мэдэгдлээс үүдэн Даваа гарагт фьючерсын зах зээл уналтанд оров. Гэхдээ БНХАУ-ын эрх баригчид гаалийн татварыг нэмэгдүүлсэний эсрэг ямар нэг хариу арга хэмжээ авахгүй хэмээн мэдэгдсэн нь хувьцааны зах зээл өсөхөд нөлөөлжээ.

Шинжээчдийн үзэж байгаагаар 2020 оны 11-р сард зохион байгуулагдах АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн гарах хүртэл БНХАУ эрх баригчид АНУ-тай тодорхой хэлэлцээр хийх сонирхолгүй байгаа аж.

Европ: АНУ болон БНХАУ-ын худалдааны маргааны асуудал намжсан, Итали улсын эрх баригч намууд хамтын Засгийн газар байгуулсантай холбоотойгоор Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

Английн фунтын ханш суларсан ч Их Британийн Ерөнхий Сайд ноён Борис Жонсон тус улсыг Европын холбооноос гаргах зорилгоор Парламентыг 10-р сарын 14-ний өдөр хүртэл хүртэл түр хугацаагаар түдгэлзүүлсэн нь FTSE 100 индекс өсөхөд нөлөөлжээ.

Худалдааны маргааны асуудлууд ХБНГУ-ын эдийн засгийг хямралд оруулж байна. ХБНГУ-ын "ifo" институтээс гаргадаг бизнес эрхлэлтийн таатай байдлын индекс унаж, 2012 оны 8-р сараас хойш хамгийндоод төвшинд хүрчээ.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Японы эрх баригчид АНУ-тай хийж буй худалдааны шинэ гэрээндээ үхрийн мах болон автомашины экспортыг нэмэх зорилгоор удахгүй хэлэлцээр хийхээр төлөвлөж байна. Японы эрх баригчид энэхүү гэрээнд 9-р сардаа багтан гарын үсэг зурахгүй бол АНУ-д энэхүү гэрээ 2020 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас өмнө хэрэгжиж эхлэхгүй билээ. Тиймээс АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп АНУ-ын фермерүүдэд ашигтай худалдааны гэрээг сонгуулиас өмнө байгуулах сонирхолтой байгаа юм.

Япон улсын ажилгүйдлийн төвшин өмнөх сарын үзүүлэлтээс 1 пунктээр буурч, 2.2%-д хүрсэн талаар тус улсын Статистикийн газраас мэдэгдсэн. Ингэснээр Японы ажилгүйдлийн төвшин сүүлийн 27 жилийн хамгийн доод цэгт хүрч, Япон улсад ажиллах хүчний дутагдал үүсэж байна. Тус улсын суурь инфляц 0.7%-тай тэнцэж байгаа нь Японы төв банкны зорилтот 2.0% инфляцийн төвшнээс бага байгаа юм.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд бууралттай хаагдлаа. Худалдааны маргааны өнөөгийн байдал болоод АНУ-ын гаалийн татвар дахин нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа нь БНХАУ-ын компаниудад сөргөөр нөлөөлж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,665.97	0.74% ▲
Dow Jones	АНУ	26,403.28	3.02% ▲
S&P 500	АНУ	2,926.46	2.79% ▲
Nasdaq	АНУ	7,962.88	2.72% ▲
S&P/TSX	Канад	16,442.07	2.52% ▲
FTSE 100	Их Британи	7,207.18	1.58% ▲
S&P/ASX 200	Австрали	6,604.20	1.24% ▲
Nikkei 225	Япон	20,704.37	-0.03% ▼
Hang Seng	Хонг Конг	25,724.73	-1.74% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	104.19
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.58
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	109.64
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	100.01
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	101.02
DBM' 2023	USD	7.250%	111.70
TDBM' 2020	USD	9.375%	102.85
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	99.53

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.089	-0.05 ▼
Libor 3M	2.138	-0.01 ▼
Libor 6M	2.037	-0.04 ▼
Libor 1YR	1.974	-0.05 ▼
US 2YR Bond	1.504	0.04 ▲
US 3YR Bond	1.427	0.04 ▲
US 5YR Bond	1.387	0.03 ▲
US 10YR Bond	1.496	0.02 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.08.30	Өөрчлөлт
USD	2,672.00	0.02% ▲
CNY	374.11	-0.76% ▼
EUR	2,949.35	-0.26% ▼
RUB	40.19	-1.28% ▼
KRW	2.21	0.00% -
JPY	25.10	0.20% ▲
CAD	2,008.42	0.11% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,520.38	-0.43% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	18.38	5.46% ▲
Зэс	USD/lb.	255.15	0.55% ▲
Нүүрс	USD/MT	65.85	-2.15% ▼
WTI газрын тос	USD/bbl.	55.10	1.72% ▲
Brent газрын тос	USD/bbl.	60.43	1.84% ▲

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VII	7.70%
Бодлогын хүү	2019. VII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VII	10.99%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VII	11.44%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VII	4.98%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VII	16.99%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VII	10.75%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 40 компанийн 218.8 сая төгрөгийн 836,046 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Жуулчин дюти фрий” /SUL/ компанийн хувьцаа 14.89%-аар буюу хамгийн ихээр өсөж 100,000.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол савхи” /UYN/ компанийн хувьцаа 14.92%-аар буурч 553.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

8-р сарын 30-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,493.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,665.97 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.74%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	218.8
Зах зээлийн үнэлгээ	2,493,472.4

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,665.97	0.74% ▲
MSE I индекс	9,044.47	0.02% ▲
MSE II индекс	7,783.50	-0.47% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	98,851	50,082,239
Ард санхүүгийн нэгдэл	38,101	48,182,160
Говь	105,991	29,712,241
Монос хүнс	209,666	14,159,528
Таван толгой	2,068	13,846,540

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Жуулчин дюти фрий	100,000.00	14.89% ▲
Ариг гал	3,550.00	10.94% ▲
Монгол шуудан	588.92	8.77% ▲
БиДиСек	899.51	7.96% ▲
УБ-БҮК	429.00	7.52% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол савхи	553.00	-14.92% ▼
Хөх ган	70.00	-9.09% ▼
Ард кредит ББСБ	68.27	-7.66% ▼
Багануур	1,100.00	-7.56% ▼
Шарын гол	1,400.00	-6.67% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	111,453,992
БиДиСек	47,486,132
Ти Ди Би Капитал	47,046,175
Новел инвестмент	41,438,643
Стандарт Инвестмент	21,845,724

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	508.50	541,136
Таван толгой	6,800.00	358,123
МИК Холдинг	13,700.00	283,718
Говь	282.43	220,327
Инвескор ББСБ	1,920.00	137,718

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Лэндмн ББСБ” ХК-ийн гүйцэтгэх захирлаар О.Болдбаатар томилогдлоо

“Лэндмн ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 8-р сарын 15-ны өдрийн хурлын 19/40 шийдвэрээр О.Болдбаатарыг компанийн гүйцэтгэх захирлаар томилсныг Санхүүгийн зохицуулах хороо хянаж үзэн 2019 оны 8-р сарын 23-ны өдрийн 7/3136 тоот албан бичгээр тус компанийн гүйцэтгэх захирал Б.Гантулгыг өөрчилж, шинээр томилогдож буй гүйцэтгэх захирал О. Болдбаатарыг “ЛэндМН ББСБ” ХК-ийн гүйцэтгэх захирлаар бүртгэсэн байна.

Шинээр томилогдсон гүйцэтгэх захирал О.Болдбаатарын мэргэжил, ажлын туршлагын талаарх дараах мэдээллийг “ЛэндМН ББСБ” ХК-аас ирүүлсэн байна:

Мэргэжил: Санхүүч, аудитор мэргэжилтэй, ОУ-ын Мэргэшсэн Нягтлан Бодогч

Ажлын туршлага:

-2004–2005 онд Турк улсын “Denge Denetim/Mazars” компанид аудитор

-2005–2006 онд “Далайван Аудит” ХХК-д Ахлах аудитор

-2006–2009 онд “Эрнст энд Янг Монголиа” компанид Ахлах аудитор

-2010–2015 онуудад “PwC Монголиа” компанид Ахлах менежер

-2015–2016 PwC компанийн Их Британи улс дахь салбарт менежер

-2016–одоог хүртэл “АНД Глобал” компанийн үүсгэн байгуулагч, санхүү эрхэлсэн захирал, “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

МХБ 2019 оны 9-р сарын 3-ны өдөр амарна

Засгийн газрын хуралдаанаар 2019 оны 9-р сарын 3-ны ажлын өдрийг бүх нийтээр амрах өдөр болгосонтой холбогдуулан Монголын хөрөнгийн бирж нь тус өдөр амарч, 2019 оны 9-р сарын 7-ны Бямба гаригт ажиллахаар болсныг мэдэгдье.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хорооны 2019 оны ээлжит XIII хуралдаан болов

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит XIII хуралдаан болж нийт 18 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар “Лүн мянганы оргил” ХЗХ-нд хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Энх нахиа” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “Сэрэлт дөл аудит” ХХК-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэлээ. Мөн “Ашид билгүүн” ХХК-ийн төлөөлөгчийн газрыг бүртгэж, Үнэт цаас, даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг зарим ХХК-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх, нэр бүхий иргэдэд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлтүүдийг бүртгэх зэрэг асуудлыг шийдэж, нэр бүхий ББСБ-уудад банк бус санхүүгийн факторингийн болон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгов.

Хуралдаанаар даатгал, үнэт цаасны чиглэлээр ажиллаж буй зарим компанийн, зарим мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зах зээлийн 2019 оны II улирлын тоймыг танилцуулав

Санхүүгийн зохицуулах хорооноос улирал тутам үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны зах зээлийн тоймыг танилцуулдаг ээлжит хэвлэлийн бага хурлаа хийлээ. Хурлаар санхүүгийн салбарын 2019 оны II улирлын үзүүлэлтийг танилцуулав.

Санхүүгийн зах зээлийн 2019 оны II улирлын хураангуй тоймыг дор толилуулж байна.

Хөрөнгийн зах зээл

2019 оны II улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй нийт 53 ҮЦК, бүртгэлтэй 307 хувьцаат компани байна. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,604.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 119.9 тэрбум төгрөгөөр буюу 4.8 хувиар өсчээ. Тайлант үед нийт 82.5 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 3.2 хувь болов. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Мөн “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХК-иар дамжуулан нийт 90.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдлээ.

Даатгалын зах зээл

Даатгалын зах зээлийн нийт хөрөнгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25.7 хувиар өсөж 354.7 тэрбум төгрөгт хүрсэн. Даатгалын салбарт давхар даатгалын нэг компани нэмэгдсэнтэй холбоотойгоор даатгалын салбарын хөрөнгийн бүтцэд өөрчлөлт гарсан ба давхар даатгалын нийт хөрөнгийн, салбарын үзүүлэлтэд эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үед 16.6 хувь байсан бол тайлант улирлын байдлаар 20.7 хувь болж өслөө. Салбарын нийт хөрөнгийн 76.7 хувийг ердийн даатгалын компаниудын хөрөнгө, 2.6 хувийг урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Банк бус санхүүгийн байгууллага

Санхүүгийн зах зээлд нийт 538 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Нийт хөрөнгийн хэмжээ 1.5 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 34.0 хувь буюу 389.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ББСБ-уудын зээлийн нийт үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 328.4 тэрбум төгрөгөөр буюу 42.7 хувиар өсөж, 11 их наяд төгрөгт хүрлээ. Нийт зээлийн үлдэгдлийн 84.7 хувийг иргэдийн зээл, 15.3 хувийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.4 дахин нэмэгдэж 360.3 мянга хүрсэн бол нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 1.6 дахин нэмэгдэж 2.3 саяд хүрсэн байна. Зээлийн бүтээгдэхүүний үнэ болох сарын жигнэсэн дундаж хүүгийн түвшин 3.3 хувьтай байна.

Хадгаламж, зээлийн хоршоо

Хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийн эрхтэй 275 хоршоо үйл ажиллагаа явуулж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хоршоодын тоо 14-өөр буурсан байна.

Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ 210.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 19.6 хувиар өссөн. ХЗХ-дын 90.5 хувь буюу 249 ХЗХ нь нийт 148.4 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн байна.

Салбарын нийт цэвэр ашиг 2.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн онтой харьцуулахад 11.9 хувиар өссөн, орлого 24.4 тэрбум төгрөг буюу өнгөрсөн оны мөн үеэс 26 хувиар өссөн.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Тариалсан талбайн 75.6 хувь соёлолто сайтай байна

Улсын ургацын комисс хуралдаж, энэ оны ургацын төлөв байдал, урьдчилсан баланстэй танилцаж, цаг агаарын төлвийг сонсож, ургац хураалтын технологийн зөвлөмж гаргах талаар ярилцлаа.

Энэ онд улсын хэмжээнд, 340.1 мянган га-д улаанбуудай, 14.8 мянган га-д төмс, 8.0 мянган га-д хүнсний ногоо, 82.4 мянган га-д тосны, 42 мянган га-д тэжээлийн ургамал, нийтдээ 512 мянган га-д тариалжээ.

Тариалалтын чанарыг соёлолтоор хүлээн авах ажлыг тариалан бүхий 13 аймгийн 86 сумын 1147 аж ахуйн нэгж, иргэдийн 337 мянган га улаанбуудайн талбайг хамруулж зохион байгуулж, нийт тариалсан талбайн 75.6 хувь буюу 250.6 мянган га талбай хээрийн соёлолтоор онц, сайн үнэлгээтэй гарчээ.

Гэвч энэ жилийн хувьд 5-р сард хүйтэн сэрүүн, хүчтэй салхи шуургатай байсан нь хаврын тариалалтын явц болон чийгийн хадгалалт, таримлын соёлолтод сөргөөр нөлөөлсний зэрэгцээ 6-р сар бүхэлдээ хуурай халуун, олон хоног хэт халсан болон зуны бороо 6-р сарын 25-наас зарим бүс нутагт 7-р сарын 4-өөс орж эхэлсэн нь буудайн өсөлтөд сөргөөр нөлөөлж бутлалт буурах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Энэ жил Булган, Хөвсгөл, Орхон, Архангай, Өвөрхангай, Увс болон Сэлэнгэ аймгийн зарим сумын нутгаар ургацын байдал хэвийн байгаа бол Төв, Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Сүхбаатар болон Сэлэнгэ аймгийн хойд талын сумдад нарны хэт их халалт, гангийн улмаас ургац бага зэрэг буурахаар байна.

Байгалийн давагдашгүй хүчин зүйл ган, хүчтэй мөндрийн улмаас Сэлэнгэ, Төв, Булган, Дархан-Уул, Хэнтий, Сүхбаатар аймгийн нийтдээ 11.0 мянган га талбайд ургац хураах боломжгүй байгаа бол болц дутуу байснаас 3.5 мянган га талбай тэжээлд шилжих төлөв гарчээ.

Цаг агаарын урьдчилсан төлвөөр 8-р сарын сүүлчээр тариалангийн бүс нутгаар цочир хүйтэрч улмаар 9-р сарын эхээр цас орох магадлалтай байна. Тиймээс ургацыг хаягдалгүй хураах технологийн зөвлөмжийг боловсруулан тариаланчдад хүргэх, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй, шуурхай зохион байгуулахад холбогдох төрийн байгууллагуудын оролцоо, ажлын уялдаа холбоог хангахад анхаарч байна.

Ургацын урьдчилсан балансаар нийтдээ 420.0 мянган тонн буудай үтрэм дээр буух төлөвтэй байгаагаас оны тариалалтад зориулан ААН, иргэд өөрсдийн хэрэгцээнд 50 мянган тонн буудайн үр нөөцлөх бөгөөд үрийн зориулалтаар 6.6 мянган тонн, тэжээлд 21.5 мянган тонн, спиртийн үйлдвэрт 8.7 мянган тонныг тус тус зарцуулах санал ирүүлснээр гурил үйлдвэрлэлд нийтдээ 333.2 мянган тонн буудай нийлүүлэх төлөвтэй байна.

Эх сурвалж: Montsame.mn

Fitch: БНХАУ-ын хойд нутгийн нүүрсний эрэлт сайн байгаа нь “Mongolian Mining Corporation”-ийн үзүүлэлтэд эергээр нөлөөлөв

БНХАУ-ын хойд нутгийн нүүрсний эрэлт сайн байгаа нь “Mongolian Mining Corporation”-ийн үзүүлэлтэд эергээр нөлөөллөө гэж “Fitch Ratings” агентлаг дүгнэлээ.

Оны эхний хагаст нүүрсний ханш харьцангуй тогтвортой байсан ч тус компанийн орлого 19.6 хувиар өсөж, 326 сая ам.доллар болсон талаар санхүүгийн тайландаа дурдсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад оны эхний зургаан сард нүүрсний борлуулалт 14 хувиар өсөж, хоёр сая тонн болсон байна. Харин мөн хугацаанд БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 9.7 хувиар өсөж, 272 сая тонн болжээ. Ийнхүү эрэлт өндөр байгаа боловч хяналт чангарч байгаатай зэрэгцээд БНХАУ-ын боомтууд дээрх нөөц өссөөр байна. Улмаар 7-р сарын эцэс гэхэд найман сая гаруй тонн болж сүүлийн хэдэн жил байгаагүй өндөр түвшинд хүрчээ. Өөрөөр хэлбэл, БНХАУ газраар тээвэрлэж байгаа нүүрсний импортоо нэмэгдүүлж байна гэсэн үг юм. Энэ нь “Mongolian Mining Corporation” шиг компани автомашинаар тээвэр хийж байгаа компаниудад ашигтай гэж “Fitch Ratings” агентлаг дүгнэсэн байна.

Монгол Улс энэ онд 42 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн бөгөөд оны эхний долоон сард 50 орчим хувиар буюу 20.9 сая тонныг гаргасан талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

Бид хэр их нүүрсний баялагтай вэ?

Монгол орны хэмжээнд 12 нүүрсний сав газар, 3 нүүрстэй талбайд энэ оны статистик мэдээгээр нүүрсний нийт батлагдсан геологийн нөөц 32.6 тэрбум тонн, онолын хувьд шинжлэх ухааны доктор Д.Бат-Эрдэнэ нь Геологи-хайгуулын нэмэлт судалгаагаар илрүүлэх боломжтой нөөц баялаг 150 тэрбум тонн байна гэсэн байдаг.

Тавантолгой ордын нөөц: Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций сумдын нутгийг дамнан орших Тавантолгойн нүүрсний ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК ба “Энержи ресурс” ХХК-иуд нь Цанхи, Бор тээг, Оорцог, Бортолгой, Онч хараат, Ухаа-худаг гэсэн 6 хэсгээс бүрдэх ба нийт 10 тусгай зөвшөөрлийн хүрээнд 5,428.82 сая тонн нүүрсний нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар хүлээн авсан байдаг.

Нарийн сухайт ордын нөөц: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийн Сухайтын нүүрсний ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Монголын алт (МАК)” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Саусгоби Сэндс” ХХК ба “Чинхуа Мак Нарийн Сухайт” ХХК-иуд нь Хүрэн толгой, Овоот толгой, Хүрэн шанд, Нарийн сухайт гэсэн 4 хэсгээс бүрдэх ба нийт 8 тусгай зөвшөөрлийн хүрээнд 1,004.94 сая тонн нүүрсний нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар хүлээн авсан байдаг.

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.